

БАРИМТ ХӨГЖӨӨХ УХААН БУЮУ  
Д.ЦЭНДЖАВЫН ЭСЭЭНИЙ ТУХАЙ

*“Буурал ижийнхээ хөлийг юугаар дулаацуулсан билээ” бүтээлийн тухай*

Б.Болд-Эрдэнэ\*

\* МУИС, НШУС-ийн Сургалтын албаны дарга, доктор (Ph.D.), дэд профессор

**Түлхүүр үг:** эсээ, бичлэгийн төрөл зүйл, эргэцүүлэл, бичлэгийн өнгө аяс, нийтлэлийн санаа

Эсээ бол хүний дотоод ертөнцийн үгэн хөрөг. Өөрийн мөн чанар, ухаан сэтгэл үрүүгээ нүүсэн, эгээрэл эргэцүүллийн хэцүү бөгөөд жаргалтай аян гэж болохоор... Тиймээс ч хүний яс чанар, хэн бэ гэдэг түүний бичиг зохиолоос танигдана.

Эсээнд хүний гэх бүх юм бий. Мэдлэг туршлага, ухаарал эргэцүүлэл, бардамнал, гуниг, хүсэл жаргал, харуусалт дурсамж, өөрийн үг, бусдын сургамж, салхи шуурга, бороо цас, айдас түгшүүр гээд үргэлжлэн үргэлжлэх амьдралын тухай их өгүүлэмжийн цар сан, ертөнц гэмээр... Гэхдээ тэр бүхнийг нэгэн эсээнд, бичиг зохиолд нэгтгэн тоочих боломжгүй нь тодорхой. Тэгэхлээр эсээ нэгэн утга, үгэнд багцлагдах эсхүл түүнийг учирлан нээхийн зорилго дор байна хэмээж болно. Эсээг зохиогч бүр өөрийн үзэл ухаан, сэтгэл зүрхээрээ бичдэг. Тэгээд ч хэл найруулга, бичлэгийн өнгө аяс өгүүлэн буй баримт, тайлбар, үзэл бодол, дурсамж дурдатгал бүр нь өөр өөр байх. Гэвч эсээ бүхэн нэг л утга, ухааны дор цуглардаг. Тэр нь ухаарч ойлгосон дурсамж, сэтгэлд оршсон үг, эргэцүүлж нээсэн үнэн юм. Энэ бол хүний амьдралын зорилго, туг зарчим.

Харин түүний бичгэн хэлбэр нь эсээ болох...

Ийнхүү нуршихын учир зохиолч, сэтгүүлч, эрдэмтэн Долгорын Цэнджавын “Буурал ижийнхээ хөлийг юугаар дулаацуулсан билээ” эсээ ботийн тухай шүүмж тайлбар бичих зорилгод байгаа юм. Номын нэр, тэргүүн эсээ энэ цагийн хүмүүний амьдрал, ухаан сэрэл, зорилго тэмүүлэлд хатуухан сануулга, эргэцүүлэхгүй байхын аргагүй үнэнийг агуулжээ. Алдар нэр, алт баялаг, өдөр тутмын амьдралын аар саархан явдал хэмнэлд алдхан бие, ахархан хугацаагаа барж яваа энэ цагийн хүмүүнд нэгийг бодуулж хоёрыг сануулах үгс нь “Буурал ижийнхээ хөлийг юугаар дулаацуулсан билээ” хэмээх эргэцүүлэлд орших... Эсээ ч том шагнал хүртсэн, Монгол даяар шашигдсан хүүгийн гэрэл гэгээгүй мухрын умгар хүйтэн өрөөнд суух ээжийн дүр, үгээр дуусч буй нь учиртай. Ээжийн тухай дурсамж, зүүд, үг сургаал, түүх, хууч яриа ийм сэтгэл сэрхийм дүр дүрслэлээр төгсөхийн учир эсээний утга зорилго. Бас хүч нөлөө. Мэдээж ийм дүр дүрслэл олон бичиг зохиол, өгүүллэг, найруулалд байдаг л байх. Гэхдээ ижийн ухаан сэтгэлийг өгүүлсэн эсээнд бол хөөрхийлэлтэй эхийн дүр үг огт өөр, зүрх огшим бууж байгаа юм. Эсээний нэг үг утгад нэгтгэгдэн, баримт үнэнийг эргэцүүлэл

эгээрлийн гэрэлд гаргах чанар үүнд байгаа хэрэг.

Энэхүү эсээнд буй өөр нэгэн утга үг бол "Төр солигдоно гэдэг чинь төлгөн хонь хургалахаас амархаан" гэх ээжийн төр засагтаа хар санаагүй ч сэтгэлийн гүндээ гуниг, харуусалтай явдаг санаашралын тухай дурсамж юм. Төр нийгмийн мөн чанарын тухай эгэл мөртлөө эгэлгүй агуу, үнэн үг гэж үүнээс өөр үгүй мэт ээ. Эсээ хэмээх бичлэг ч хүний үзэж өнгөрүүлсэн амьдралын дурсамж яриа, үзэл бодол, эргэцүүлэл сургаалаар дамжуулан нийгэм, цаг үеийн үйл явдал, асуудлыг дүгнэн тайлбарлаж, нээн өгүүлэх нийтлэл зүй, сэтгүүл зүйн зорилго чанар оршдогийн жишээ энэ. Ээжийн хүүдээ хэлсэн эгэл энэ үгээр ч хорьдугаар

зууны Монголын түүхийн гүн бат эргэлзэшгүй үнэн, мөн чанарыг ч өгүүлж болмоор. Ардын хувьсгал, тусгаар тогтнол, бүгд найрамдах засаглал, хэлмэгдүүлэлт, нэгдэлжих болоод атар газар эзэмших хөдөлгөөн, ардчиллын давалгаа гээд их өөрчлөлт, хөдөлгөөний эрин цагийг үзсэн монгол хүний ухаан, сэтгэлийн хат, тэвчээр, чинад чанар энэ бүхэн "төр солигдоно гэдэг төлгөн хонь хургалахаас амархан" гэсэн үгэнд оршиж байна. Зохиогчийн эсээ ч ээжийн тухай гэхээсээ их ухаан, амьдралд хат суусан хүний сэтгэлийн тэнхээний тухай өгүүлжээ. Эсээг ч дэлхий нийтээр үзэл тайлбарын хувьд маргаантай, эсвэл тодорхой нэг ойлголт дүгнэлтэд хүрээгүй нээлттэй хүн, нийгмийн цаг үеийн асуудлыг тодотгох зорилго бүхий уран зохиол гүн ухаан, нийтлэл зүйн гурамсан утга зохиол, бичлэгийн төрөл хэмээн тодорхойлдог. Бас хувь хүний дотоод ертөнцийг

илэрхийлэгч нээлттэй, чөлөөт зохиомж бүхий бичлэг ч гэх нь бий. Түүнчлэн шинжлэх ухааны өгүүлэл, уран зохиолын өгүүллэг, гүн ухааны тайлбарын нэгдэл өөр хоорондын солбилцол дээр оршдог бүтээл ч хэмээдэг.

Аль ч талаас харсан "Буурал ижийнхээ хөлийг юугаар дулаацуулсан билээ" эсээ нь зохиогчийн хэлсэнчлэн монгол сэтгэлгээний эсээ болж чаджээ.

Нэгэн утга санааны мөртлөө олон бодол, эргэцүүллийнх, тэгсэн мөртлөө тэр бүх бодит үйл, дүр, дүрслэл, дурсамж, яриа нэгэн үгэнд шингэн нэгтгэгдсэн нь монгол эсээний нээлт ажээ.

Хүн гэгч амьтан төрөхөөс төгсөхийг хүртэл орчлон ертөнц, амьдрал, цаг үеийнхээ тухай эргэцүүлж, ухаарч, өөртөө нээх жам

тавилантай нэгэн. Тэгээд өөрийн "нээлтээ" бусдад магадгүй өөртөө дахин нягтлан тодотгох нь түүний жаргал болоод зовлон аж.

Эсээг бичих хэцүү ч түүнийг ухааран ойлгох нь бүр хэцүү гэмээр. Уншигч нь ч тэр, зохиогч өөрөө ч тэр эсээнээс дахин дахин шинийг нээдэг байх. Баримт бодол гэдэг нэгэн өнгө утгынхаараа хэзээд байдаггүй. Урсан одох гол мөрөн адил өөрчлөгдөх, өөр өөрөөр гялалзан байдаг толио адил амьд ертөнц. Эсээг хүн зөвхөн оюун ухаанаараа бус сэтгэл зүрхээрээ унших, бас унших төдийгүй амьдарч үзсэн мэт адилсан догдолж баясан баярлаж, гуньж эргэцүүлэн уншдаг. Эгэл дурсамж, үг, баримтын гүнд орших их ухаан, сэтгэлийн өнгө гэрлийг нээнэ гэдэг эсээний далд чанар. Хүмүүний амьдрал гэдэг ч өөрөөрөө урсах бүхнийг өөртөө тунгаан ширгээдэг хатуу мөртлөө мөнхийн төгсөшгүй

«

*Эсээ бол хүний дотоод ертөнцийн үгэн хөрөг. Өөрийн мөн чанар, ухаан сэтгэл үрүүгээ нүүсэн, эгээрэл эргэцүүллийн хэцүү бөгөөд жаргалтай аян гэж болохоор... Тиймээс ч хүний яс чанар, хэн бэ гэдэг түүний бичиг зохиолоос танигдана.*

»

үргэлжлэл. Зохиогчийн нэгэн эсээнд ийн бичжээ.

“Төрийн тэргүүн Самбуу гуай таалал төгсч Сүхбаатарын талбай дүүрэн хүмүүс цуглаж, бүрхээг эвгүй өдөр бага багаар дусагнаж байв. Индэр дээр Ю.Цэдэнбалаас авахуулаад тэр үеийн удирдагчид бүгд л харагдаж байлаа. Хэдэн цагаар үргэлжилдэг Майн баяр, октябрийн баяраар энэхүү өвгөн буурал удирдагч даарч хөрсөн янзтай ганцаархнаа л сандал дээр суугаад гараараа дохин харагддаг сан” гэжээ. Монгол төрийн өвөө хэмээгддэг энэ эрхэм хүний тухай үүнээс өөрөөр хэрхэн яаж хэдхэн мөрөнд гайхалтай бичих билээ.

“Миний мэдэхээс” уяа болгон нь хурдны удамтай, уясан даага болгон нь түрүүлдэг” ОУ-ын математикийн олимпиадад МУ-аа үргэлж цоллуулж ирсэн, алтан гавалт математикчдыг төрүүлдэг МУИС-ийн багш Дашдорж гуай Ардын багш бил үү” гэсэн асуулт мөртлөө хариулт, эргэцүүлэл боловч үнэн үгээр энэ цагийн “Балайрал”-ын мөн чанарыг өөрөөр юу гэж нотлох вэ?!

Бас “Одоо сумаар нэг уйдсан, хэлхэлдсэн овойж оцойсон залуус байна. Тэд айлд ороод өглөө ч сууж л байна, үд дунд ч сууж байна, орой нар унины толгойд хүрэхэд сууж байна. Ялангуяа хөдөөх монголчуудын нэг ажил “СУУХ”. Ёстой наалдан падаар наалгасан юм шиг ховорохгүй” хэмээн энээ цаг үеийн үнэнийг тодорхойлжээ.

Харин өнгөрсөн цаг үеийн мөн чанарыг “Шуурганд уруудагсад” эсээнд “Энэ чинь Лоохуузын хэрэгтэй Дашнамжил гэгч шүү дээ... Хөөрхий тэр хар хүний сэтгэлийг сэргээх, бас чиг хэрэндээ өмгөөлөх санаатай “Цагаан давс олборлогчид” гэсэн нэг муу мэдээндээ зориуд нэрийг нь хавчуулав. Хэд хоногийн дараа “Нам, засгийн төв сониньг эсэргүүний индэр болгож болохгүй... Хөөрхий дөө муусайн шуурганд уруудагсдыг ёстой сүүдэр мэт дагаж, сүнс мэт эргэлдэж

явдагийг тэгэхэд мэдэв” хэмээн баримтаар тодотгосон байх юм.

Ийнхүү ертөнцийн мөн чанар хэзээд үргэлж нэгэн зүйл болох үнэнийг нээх нь эсээний онцлог, “давуу тал” аж. Мэдээж түүнийг хүн бүр л өөрийнхөөрөө бүтээн туурвина. Гэхдээ энгүүн нэгэн баримт, дурсамж, үгэнд нийтлэг үнэн ухаан бодлын охийг багтаах эсхүл агуу их үйл зорилгыг нэгээхэн үйлд тодотгох нэгэн чанарт бүх эсээ багтана. Ерөөс эсээч чанар буюу хүний дотоод ертөнцийг шинжлэн нягталж, дүрслэн хэтийггэж, дурсан эргэцүүлэх нь оюун бодлын “үр жимс” билээ. Тиймээс эсээг буй утга агуулгаар нь бус хүн чанар, амьдран үзсэн туршлага, түүнээс дээжлэх ухаан сэтгэлийн цараагаар ухан ойлгодог учиртай.

Зохиолч, сэтгүүлч, эрдэмтэн Д. Цэнджавын “Буурал ээжинхээ хөлийг юугаар дулаацуулсан билээ” эсээ ботийг ч дахин дахин уншиж, уншсанаа эргэцүүлж, тэр чинээгээр оюун бодлын их далайд хөвөхийн жаргалыг үзэхийн жишиг болсон бүтээл болжээ.

Тэгээд ч зохиогч тэр бүхнийг өөртөө нээсэн нээлт гэж хүндэтгэнэ. Оюун далай номоос эхтэй гэдэг. Чухамдаа энэ үг энэ номд л бүрнээ нийцэж байна.

## Резюме

В данной рецензии автор анализирует мастерство изложения и глубину мысли известного журналиста, писателя Д. Цэнджава на примере сборника эссе. Отличительными чертами эссе Д.Цэнджава являются красота изложения, мастерский подбор слов, удачные аналогии, глубинное проникновение в душу человека и т. д.